



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/52

Амардалтай

Бог малын мялзан өвчнөөс урьдчилсан
сэргийлэх яаралттай дархлаажуулалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Зохиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлага тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3,9.4,9.5,9.6, дахь заалтууд, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22 -ний өдрийн 266 дугаар тогтоол "Хорио цээр, хязгаарлалтын дэглэм"-ийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам, Мал эмнэлгийн ерөнхий газрын 2022 оны 07 сарын 07-ний А/158 дугаар тушаал "Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх яаралттай дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ

1. Бог малын мялзан өвчнөөс урьдчилсан сэргийлэх яаралттай дархлаажуулалтын төлөвлөсөн хуваарийн дагуу сэжигтэй болон голомтын бүсийн мэдрэмтгийн мал сүргийг 2022 оны 07 сарын 09-нөөс эхлэн 5 хонгийн хугацаанд шуурхай зохион байгуулж ажиллахыг даалгасугай

2. Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Наранцэцэг (МЭТ-ийн дарга)

Гишүүд

М.Даваацэрэн (Дэлгэрбаяндалай МЭҮН-ийн эмч)

М.Ганьхүү (Арвин тэгш баялаг МЭҮН-ийн эмч)

Э.Дэлгэрмаа (Дэлгэрбаяндалай МЭҮН-ийн эмч)

Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

3. Бог малын мялзан өвчнөөс урьдчилсан сэргийлэх дархлаажуулалтын товыг малчдад зарлан мэдээлэх, газрын маршрут гаргахыг 2-р багийн Засаг дарга (Г.Сосорбурам), дархлаажуулалтын хуваарийн дагуу технологит хугацаанд шуурхай зохион байгуулж ажиллахыг малын эмч (М.Даваацэрэн), (Э.Дэлгэрмаа), (М.Ганьхүү) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Дархлаажуулалтын явцад хяналт тавьж, мэргэжилт арга зүй заавар зөвлөмж өгөх, вакцинжуулалтын ажлын үр дүнг 2022 оны 07 дугаар сарын 18-ний дотор багтаан орон нутгийн удирдлага болон мэргэжлийн байгууллагад танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Д.Наранцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАЯРСҮХ